

# АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЦАВУУ, ГАЗ ҮНЭРТЭЖ ДОНТОХ /ТОКСИКМАНИЯ/, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

## LEGAL REGULATION ON PREVENTING AND COMBATING AGAINST HOUSE HOLD GLUE AND GAS ADDICTION



### Г.ГАНТӨМӨР

Отгонтэнгэр их сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор, дэд профессор

### GANTUMUR G.

Lecturer of the Department of International criminal law, Otgontenger University, Ph.D, Associate professor

### Ц.ДОЛГОРСҮРЭН

Отгонтэнгэр их сургуулийн оюутан

### DOLGORSUREN TS.

Student of Otgontenger University

**Товч агуулга:** Токсикмания буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох үзэгдэл, сэтгэцийн эмгэгийн ойлголт, мөн чанар, түүний хор аюулыг тодорхойлж, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, эрх зүйн орчныг сайжруулахад оршино.

**Abstract:** This article analyzes and determines the approaches of enhancing its legal regulation on preventing and combating against house hold glue and gas addiction through determining its nature and toxicity as well.

**Түлхүүр үгс:** Дон, үнэрлэж донтох, токсикмания, мансуурах, наркомания, дэгдэмхий бодис, ингальт, газ, цавуу.

**Key words:** Addiction, narcotic addiction, toxic mania, narcomania, volatile gas

*Мансуурна гэдэг чинь ертөнцийг  
3D-ээр харж байна гэсэн үг*

Монгол Улс мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудалд онцгойлон анхаарал хандуулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар идэвхтэй ажиллаж байгаа хэдий ч мансууруулах бодисоос дутуугүй хор аюул дагуулж хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлтэй байдалд оруулж буй ахуйн хэрэглээний цавуу, газыг үнэртэж донтох асуудалд зохих анхаарал хандуулахгүй байгаа нь нууц биш.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад байгалийн хийн түлшээр ажилладаг тээврийн хэрэгслийн тоо өссөн, үйлдвэрлэлийн зориулалтаар болон

<sup>1</sup> <http://www.medee.mn/> - Мансуурлын эсрэг эмчилгээ хийлгэж буй хүүхдийн ярилцлагаас

ахуйн хэрэглээнд газыг өргөн хэрэглэх болсонтой холбоотойгоор түүний хяналтгүй хэрэглээ ихэссэн, эцэг эхийн анхаарал халамж сулаас хүүхэд бусдад уруу татагдах, өөрсдийн томоогүй сониуч зандаа хөтлөгдөн ахуйн хэрэглээний газ, гутлын шар цавуу зэрэг органик бодисыг үнэртэж донтох явдал газар авах боллоо. Үүний тодорхой жишээ нь өсвөр насны хүүхдүүд газ үнэртэж донтсон, улмаар үнэртэж байсан газ нь дэлбэрч нас барсан, түлэгдэж гэмтсэн тухай мэдээлэл хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр ойр ойрхон гарах болсон явдал юм.

Токсикмания буюу дэгдэмхий бодис (ахуйн хэрэглээний газ, цавуу ба бусад бодисыг) үнэртэж донтох үйлдэл нь хүүхдийн сэтгэцэд өөрчлөлт орох, биеэ хянаж удирдах чадваргүй болох, үүнээс болж унаж бэртэх, гэмтэх, амь насаа



алдах, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт хэргийн золиос болох зэрэг сөрөг үр дагавар, эрсдэлд хүргэдэг нийгэмд аюултай үйлдэл, зан үйлийн эмгэг мөн.

Дэгдэмхий бодис үнэртэж донтох нь мансуурахаас дутуугүй хүний сэтгэц, бие организмд хор аюултай, хараат байдал үүсгэдэг, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодис хэрэглэж мансуурахын угтвар нөхцөл болдог, ихэнх тохиолдолд уг үйлдэл даамжирч, мансуурах эрсдэлийг дагуулдаг. Учир нь дэгдэмхий бодис нь тодорхой хугацааны дараа донтогч этгээдийн донтох, мансуурах хэрэгцээг хангаж чадахгүй болмогц дараагийн шат болох мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэж мансуурах шатанд шилжих нь олонтой. Өөрөөр хэлбэл токсикмания буюу дэгдэмхий бодис үнэрлэж донтох нь мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэж мансуурах буюу наркоманийн төрсөн дүү гэж хэлж болно.

Иймд нийгэмд тулгарч буй уг асуудалд та бүхний анхаарлыг хандуулж энэ төрлийн хууль бус үйлдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэхийг зорьлоо.

Энэхүү өгүүлээр токсикмания буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох ойлголтыг хэл зүйн үүднээс зөв тайлбарлах; дэгдэмхий бодис үнэрлэж донтох сэтгэцийн эмгэгийг сэтгэц эмгэг судлалын үүднээс тодорхойлж, клиник шинжийг авч үзэх; уг үзэгдэлд хууль зүйн үүднээс тодорхойлолт өгөх, түүний нийгмийн хор аюул, шалтгааныг авч үзэх; дэгдэмхий бодис үнэртэж донтохтой тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалтыг судлах, түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох; дүгнэлт, санал гаргах зорилтыг дэвшүүлэн бичлээ.

Үнэртэж донтох (токсикмания) ойлголт, шинж: Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид “Дэгдэмхий бодис үнэрлэж донтох” буюу “токсикмания” гэдгийг тодорхойлсон нэгдсэн ойлголт, нэр томъёо байхгүй

байна. Иймээс “дон”, “донтох” гэдэг үгийг хэл шинжлэл, сэтгэл судлал болон хууль зүйн шинжлэх ухаанд эрдэмтэн судлаачид хэрхэн тайлбарласныг авч үзье.

Дон, донтох гэдэг нь “Mania” гэсэн латин үгнээс үүсэлтэй бөгөөд англи хэлэнд “дон”, “мансуурал” гэсэн утгатай. “Дон” буюу “Mania” нь “dependence” буюу хараат байдал, “deviance” буюу хэвийн байдлаас хазайх гэсэн утгыг сэтгэц эмгэг судлалын шинжлэх ухаанд илэрхийлдэг байна.<sup>2</sup>

Олноо Я.Цэвэлийн гэж алдаршсан Монгол хэлний товч тайлбар тольд “дон” гэдэг үгийг ад хий юм, ад зэтгэр шүглэх, аливаа зүйлд хэт дур хүсэлтэй болох<sup>3</sup>, “донтох” гэдгийг дон шүглэх, дон нөхцөх<sup>4</sup> гэж тайлбарласан бол, Монсудар хэвлэлийн газраас гаргасан Монгол хэлний тайлбар тольд “дон”- ад хий юм, элдэв үйлд тэмүүлэх зан үйл, хэтэрхий их дуршил<sup>5</sup>, “донтох”- дон нөхцөх, хэт их шунан дурлах, хорхойсох<sup>6</sup> гэж хэл зүйн хувьд тайлбар өгчээ.

Хууль зүйн агуулгаар нь донтохыг “мансуурах дон” гэдэг талаас нь голчлон авч үзсэн байдаг. 2002 онд батлагдсан “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй тэмцэх тухай” хуулийн 3-р зүйлийн 3.1.5-д “мансуурах дон” нь мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгэцийн өвчин<sup>7</sup> гэж заасан бол, доктор Б.Болдбаатар, Ж.Мөнхболд нар “Мансуурах дон” гэдэг нь хүний бие эрхтэн мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн хамааралд орж амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үед явагдах, эцэст нь бие махбодь болон сэтгэцийн үйл ажиллагааны гүнзгий

<sup>2</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004. 29 дэх тал

<sup>3</sup> Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., УХГ. 1966. 200 дахь тал

<sup>4</sup> Я.Цэвэл. Мөн тэнд. 201 дэх тал

<sup>5</sup> Монгол хэлний тайлбар толь. УБ., Монсудар. 2014. 408 дахь тал

<sup>6</sup> Мөн тэнд. 409 дэх тал

<sup>7</sup> Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2002. № 46

хямралаар илэрдэг хүнд өвчин юм<sup>8</sup> гэж тодорхойлжээ.

Дээрх нэр томьёоны тайлбар, тодорхойлолтуудоос үзэхэд “дон”, “донтох” нь аливаа төрлийн бодис болон бусад хүчин зүйлийн нөлөөнд орж, бие сэтгэцийн хувьд хамааралтай болох байдал гэж ерөнхийд нь ойлгож болно.

“Токсикмания” гэдэг үг нь “toxic”, “mania” гэсэн хоёр үгээс бүтэх ба үгчилбэл “дэгдэмхий хорт бодист донтох” гэсэн утгыг хэл зүйн хувьд илэрхийлнэ. Бид энэхүү сэтгэцийн эмгэг зан үйлийг хэл зүйн хувьд “дэгдэмхий бодис үнэртэж донтох” гэж томьёолох нь зүйтэй гэж үзэж байна.

Манай улсад дэгдэмхий бодис үнэрлэж донтох асуудлыг хууль зүйн шинжлэх ухаанаас илүүтэйгээр сэтгэц эмгэг судлалын шинжлэх ухаанд сэтгэц идэвхит эм, бодисын шалтгаант сэтгэцийн эмгэг, зан үйлийн эмгэг талаас нь судалсан гэж хэлж болно. Тухайлбал, сэтгэц эмгэг судлалын шинжлэх ухааны манай нэртэй эрдэмтэн Л.Эрдэнэбаяр уг ойлголтыг донтох эмгэгийн нэг төрөл болох талаас нь өөрийн хэд хэдэн бүтээлд тусгайлсан судалсан байдаг.<sup>9</sup>

Сэтгэц эмгэг судлалын шинжлэх ухаанд донтох эмгэгийг сэтгэц идэвхит эм бэлдмэл, бодист донтох эмгэг, сэтгэцийн хүрээнд донтох гэж хоёр ангилдаг ба сэтгэц идэвхит эм бэлдмэл, бодист донтох нь

- Мансуурах дон (Наркомания)
  - Дэгдэмхий бодис үнэртэж донтох (Токсикомания)
  - Архинд донтох өвчин (Алкоголизм)
- гэж төрлүүдтэй.<sup>10</sup>

Токсикмания буюу дэгдэмхий бодис үнэрлэж донтох ойлголт, түүний мөн чанар, уг үзэгдлийн шинжийг хууль зүйн үүднээс тодорхойлох нь энэ

төрлийн хууль бус, нийгэмд аюултай зан үйлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх шаардлагаас урган гарна.

Шинжлэх ухааны доктор, профессор Л.Эрдэнэбаяр “зан үйлийн эмгэгтэй зарим хүүхэд залуучууд өөрийн амьдралын буруу дадал, зан үйлээсээ болж дэгдэмхий бодисуудыг хэрэглэж сэтгэлийн хөөрөлд орж уг дэгдэмхий бодисынхоо хараат байдалд орохыг дэгдэмхий бодисуудад донтох өвчин” гэж тодорхойлсонтой үндсэндээ санал нийлж болох юм.

Бидний үзэж байгаагаар токсикмания буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох гэдэг нь ахуйн хэрэглээний цавуу, газ, бензин, ацетон, будаг шингэлэгч зэрэг дэгдэмхий, ууршигтай чанарт химийн хорт бодисыг үнэртэн амьсгалах замаар бие организмдаа нэвтрүүлснээр уг бодис тодорхой хугацаанд хүний төв мэдрэлийн системд нөлөөлж, орчин тойрноо мэдрэх, бодит байдлыг хүлээн авах, сэтгэн бодох чадвар алдагдаж, сэтгэл зүйн хувьд бодит байдлаас тасран, хэт амирлангуй болох, тайвшрах, сэтгэл хөөрлийн (эйфорий) байдалд орох, хий хоосон зүйл олж харах, түүнээсээ баяр, таашаал авах, уг бодисын үйлчилгээ гарсны дараа бие махбодь хэвийн байдалд эргэн ордог, болж өнгөрсөн үйл явдлыг ойлгохгүй, санахгүй байдалд хүргэдэг, улмаар тухайн бодист дасч дахин хэрэглэхийг хүсэх, хорхойсох, шунан дурлах, донтох зан үйлийн эмгэг байдлыг хэлнэ.

Дэгдэмхий бодис, тэдгээрийн шинж, төрөл:

Үнэрлэж донтох эмгэгийг үүсгэдэг эх сурвалж нь “toxic”, “токсичные вещества” буюу дэгдэмхий бодис бөгөөд олон улсад “ингалат” гэсэн нэршлээр хэрэглэгддэг. “Ингаляция” гэдэг нь “амьсгал авах” гэсэн утгатай латин үг. Найрлагадаа бензол, трихлорэтан, перхлорэтилен, трихлорэтилен, эфир, нитроксил, амилнитрат, галогенчлагдсан нүүрстөрөгч зэрэг сэтгэц идэвхит бодисыг агуулсан, үнэрлэх хэлбэрээр хэрэглэхэд төв мэдрэлийн

<sup>8</sup> Б.Болдбаатар, Ж.Мөнхболд. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа. УБ., 2012. 7 дахь тал

<sup>9</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004. Шүүхийн сэтгэц эмгэг судлалын лекцүүд. УБ., 2009. Мансуурал судлалын үндэс. УБ., 2014. зэргийг дурдаж болно.

<sup>10</sup> Л.Эрдэнэбаяр. Шүүх сэтгэц эмгэг судлалын лекцүүд. УБ., 2009. 112 дахь тал

<sup>11</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004. 35 дахь тал



системд нөлөөлж хараат байдлыг үүсгэх чадвартай химийн бодисуудыг “ингальянтууд” гэсэн ерөнхий нэрээр нэрлэж заншжээ.

Ингальянтуудын тоонд үйлдвэрийн болон аж ахуйн хэрэгцээнд өргөн ашигладаг анхилуун эсвэл онцгой хурц үнэртэй химийн бодисууд болох органик уусгагчид, цэвэрлэгч бодисууд, толбо арилгагч бодисууд, ялаа хортон шавьж устгагч зарим бодисууд, азотын хүчлийн давс бүхий нэгдлүүд, нитри агуулсан будгууд, маажингууд (лак), өрөө тасалгааг ариутгагч шингэн, бензин, дизелийн түлш, эфир, синтетик цавуунууд, байгалийн хий болон бусад дэгдэмхий бодисууд орно.<sup>12</sup>

Дэгдэмхий бодисыг химийн бүтэц, нэгдэл, шинж чанараас нь хамаарч дараах 3 үндсэн бүлэгт хувааж болно.

1. Ердийн дэгдэмхий органик нэгдлүүд (цавуу, ахуйн хэрэглээний газ төрөл бүрийн гэр ахуйн химийн бодисууд)

2. Дэгдэмхий нитритүүд

3. Мэдээ алдуулагч (азотын хий)

Мөн сэтгэц идэвхит дэгдэмхий химийн бодисуудыг зориулалтаар нь төрлүүдэд хуваадаг. Үүнд:

1. Аэрозолууд (ахуйн болон гоо сайхны хэрэглээний төмөр саванд даралтаар савлагдсан химийн бодисууд)

2. Газолин (байгалийн хий болон нефтийг нэрэх замаар гаргаж авсан шингэн бодис, бензин, түлш)

3. Синтетик цавуунууд

4. Органик уусгагчид, химийн цэвэрлэх бодисууд

5. Нитробензол ба нитратууд

6. Толуол, ацетон, бензол, галогенчлагдсан нүүрстөрөгчийг агуулсан бусад ингальянтууд

Ахуйн зориулалтаар түгээмэл хэрэглэгддэг дэгдэмхий бодисууд:

- Цавуулаг бодисууд (Модны цавуу, гутлын цавуу, дугуйн бүрээсний цавуу)

- Газ буюу шингэрүүлсэн хий

- Бусад дэгдэмхий бодисууд (агаар цэвэрлэгчид, агааржуулагч, дезодрант буюу хөлс хулмасны үнэр дарагч бодисууд, ялааны шүршдэг

<sup>12</sup> Л.Эрдэнэбаяр. Мөн тэнд. 42 дахь тал

хор, үсний лак, төрөл бүрийн будгууд, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар хэрэглэгдэх тос арилгагч, толбо арилгагч гэх мэт хуурай цэвэрлэгчид, хумсны будаг арилгагч шингэн, ахуйн будаг арилгагч шингэн, маркерууд, тест үзэх шингэнүүд юм).

Өргөн хэрэглэгддэг ахуйн хэрэглээний дэгдэмхий бодисын (ингальятууд) онцлог:

1. Элбэг олдочтой (бараан зах, супермаркет, дэлгүүр, ТҮЦ, гудамжинд гар дээрээс гэх мэтчилэн хаанаас ч авч болдог), хямд үнэтэй. Жишээ нь: гутлын шар цавуу 300-500 төгрөг, ахуйн хэрэглээний 220 граммаар савласан газ 1600-1800 төгрөг, будаг шингэлэгч 3000 төгрөг байдаг.

2. Олон улсын хэмжээнд дээрх бодисыг үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхийг хориглоогүй, тусгай зөвшөөрөл шаарддаггүй, тусгай хяналтад ороогүй, ахуйн зориулалтаар чөлөөтэй хэрэглэгддэг.

3. Дангаар буюу түүхий эд байдлаар нь шууд хэрэглэх, эсвэл хооронд нь хольж найруулж хэрэглэж болдог, эсвэл ахуйн олон төрлийн бүтээгдэхүүний найрлагад ордог бодисууд байдаг.

4. Бэлтгэж хэрэглэхэд ямар нэгэн тусгай мэдлэг, тусгай багаж төхөөрөмж шаарддаггүй, шууд үнэртэж хэрэглэж болдог.

5. Мансуурал буюу сэтгэлийн хөөрөл (айфорий) амархан үүсгэдэг, оруулдаг.

6. Агаарт уурших болон бие организм нэвтэрч тодорхой хугацаанд үйлчилснээр үйлчлэл нь дуусдаг, үйлчлэх, үргэлжлэх хугацаа нь богино байдаг.

7. Хэрэглэсний дараах шинж тэмдэг нь харьцангуй амархан арилдаг, сэтгэцийн хувьд хэвийн байдалд хурдан буцаж ордог.

8. Үзүүлэх гаж нөлөө, хорвуу чанар харьцангуй багатай, хор нөлөө нь аажмаар илэрдэг, ойролцоогоор 2-3 сарын дараагаар хараат байдал, донтох эмгэг үүсдэг зэрэг болно.

Судалгаанаас харахад дээрх шинж чанараас шалтгаалан насанд хүрээгүй хүмүүс гутлын шар цавуу, ахуйн

хэрэглээний газ үнэртэн донтох явдал түгээмэл байна.

Цавуу үнэрлэж донтох: Үнэрлэж донтох дон үүсгэдэг бодисуудын нэг бол гутлын цавуу юм. Гутлын шар цавуу бол сэтгэц идэвхит пропан, бутан зэрэг химийн олон төрлийн хорт нэгдлээс тогтох бөгөөд буруу хэрэглэхэд токсикмания үүсгэдэг дэгдэмхий хорт бодис юм.<sup>13</sup> 1990-ээд онд манай хүүхэд, залуучууд голчлон шар цавуу үнэртдэг байсан боловч сүүлийн жилүүдэд хэрэглээ нь багассан.

Ахуйн газ үнэртэж донтох: Ахуйн хэрэглээний газ буюу шингэрүүлсэн хийн түлш нь нүүрстөрөгчийн пропан бутаны холимог нэгдэл бөгөөд сүүлийн жилүүдэд хүүхэд залуучууд энэ төрлийн дэгдэмхий бодисыг үнэрлэн донтохыг илүүд үздэг болсон. Бидний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн зарим нь бусдыг даган дуурайж анхлан ахуйн хэрэглээний зажигалка буюу хийн тамхи асаагуурыг үнэрлэн донтож эхэлсэн тухайгаа ярилцлагын явцад өгүүлж байсан нь анхаарал татаж байна.

Цавуу, ахуйн хэрэглээний газ хэрэглэсний шинж:

Эдгээр бодис хэрэглэсэн мансуурагчдын биеэс болон тэдний хувцас, ойр тойрноос тухайн бодисын үнэртэй төстэй үнэр үнэртдэг. Нүүр царай, гарын арьс нь улаавтар өнгөтэй, хавдаж хөөсөн байдалтай, хамрын салст гэмтдэг учраас хамраараа муу амьсгалдаг. Биеийн дээд хэсэгт цус их шахагдсанаас болж гар хүрэхэд халуун байна. Уруулын эргэн тойронд ялангуяа ам, амны хөндий, жавьж, ам тойрсон хэсгийн арьс, зөөлөн эд улайсан, бага зэрэг түлэгдэж гэмтсэн байдаг байна. Цавуу, ахуйн хэрэглээний газыг насанд хүрээгүй хүмүүс үнэртэх, утах аргаар хэрэглэх нь элбэг байдаг ба олноороо хүнгүй газар, байшингийн дээвэр, хонгил, орц, хуучин эзэнгүй байшинд орогнон үнэрлэдэг. Тэднээс химийн бодис шингээсэн хөвөн, гялгар уут, даавуу, цаас, төмөр лааз, сав олддог.<sup>14</sup>

<sup>13</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004. 34 дэх тал

<sup>14</sup> Б.Болдбаатар, Ж.Мөнхболд. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн

Цавуу, ахуйн хэрэглээний газ хэрэглэж донтохын шинж, хэрэглэсний дараах үр дагавар:

Цавуу, газанд нэг удаа хордох буюу үнэрлэж мансуурах үед нулимс гарах, нүд харанхуйлах, толгой дүйрэх, эргэх, чих шуугих, орчны юм дайвалзах, огиулах, бөөлжих зэрэг шинж тэмдэг ажиглагдана. Мөн газ буюу шингэрүүлсэн нүүрс-төрөгчийн пропан бутаны холимог нэгдлээр анхлан амьсгалахад сэтгэл хэт хөөрөх, эсвэл сэтгэл тайвшрах, нойрмог байдалтай болох, зүрхний хэм алдагдах, санах ой түр зуур алдагдах шинж тэмдэг илэрнэ.

Ууршдаг химийн бодис үнэрлэн мансуурдаг донтой хүмүүст хамар хоолой, улаан хоолойн дээд хэсэг болон амьсгалын замын салст бүрхэвчүүдийн үрэвсэл, элэгний үрэвсэл, арьсны үрэвсэл ба зүрхний булчингийн тэжээлийн өөрчлөлт тод илэрдэг. Тодруулбал газаар амьсгалах нь уушгиар дамжин уураг тархинд нөлөөлнө. Ингалянтаар амьсгалж эхэлснээс хойш 5 минутын дотор уураг тархи хордож эхэлнэ. Ингалянтуудын нэр төрөл болон тунгаас хамааран тэдний үзүүлэх нөлөө 30 минутаас хэдэн цагаар үргэлжилж болно. Жишээлбэл 1 хувийн газолины уусмалаас 15-20 удаа амьсгал авахад хэдэн цагаар үргэлжилсэн хүчтэй хордлого үүснэ. Ингалянтын 20 орчим хувь нь амьсгал гаргахад гадагш ялгарч, үлдсэн хувь нь элгэнд бодисын солилцооны урвалд ордог.

Ингалянтууд буюу дэгдэмхий бодис хэрэглэснээс хойш 4-10 цагийн хугацаагаар тэдгээр нь цусанд байдаг.

Ингалянтын эмгэг байдал буюу цочмог хордлого нь 3 үе шатыг дамжин явагдана.

Эхний үе буюу 1-р шатанд ингалянтаар амьсгалж байгаа үед согтолт мансуурал илэрнэ. Сэтгэл хөөрөн баясаж олон үгтэй болно. Биеийн тэнцвэр алдагдаж, алхах, гишгэхдээ ганхана. Ухаан санаа балартна. Ухаан балартсан үед болсон үйл явдлыг ухаан саруул болсны дараа санахгүй.

Хордлогын 2-р шатанд сэтгэц эсрэг ажиллагаа. УБ., 2012. 48 дахь тал



хөдөлгөөний догшролд орж түрэмгий авирлах шинж ажиглагдана. Эсвэл унтаа буюу нойрмог байдалтай болно.

Хордлогын 3-р шатанд удаан хугацааны эмгэг нойр үүснэ. Зүрх судасны үйл ажиллагаа суларч цусны даралт буурна. Бүр хүнд хордсон тохиолдолд амьсгалын төв дарангуйлагдаж хүний зүрх нь зогсож нас барж болно.<sup>15</sup>

Мансуурсны дараа буюу хэрэглэж дууссаны дараа хүний сэтгэл санааны байдал нь үл төлөвшсөн, тэнцвэргүй тогтворгүй байдалтай, эсрэг тэсрэг шинжтэй байна.<sup>16</sup> Энэ нь мансуурсан этгээд нь дэгдэмхий бодисыг үнэртэн, мансуурч дууссаны дараа сэтгэл хөөрлийн тайвшралын байдлаас гарч хэвийн байдалд орохдоо зарим тохиолдолд хэрэглэснээсээ таашаал авсан, баяр хөөртэй байх, эсвэл эсрэгээр сэтгэл санаагаар гуньж гутрах, идэхгүй, уур уцаартай, уй гашууд автах шинжээр илэрнэ.

Токсикмани буюу үнэрлэж донтох өвчнөөр өвчлөх шалтгаан:

Аливаа зүйлд донтох нь олон төрлийн шалтгаантай боловч тэдгээр нь гадаад (environmental), мөн хувь хүний сэтгэл зүйн болон генетикийн (individual and genetic factors) хүчин зүйлтэй холбоотой байдгийг сэтгэл судлалын шинжлэх ухаанд тогтоожээ.<sup>17</sup>

Гадаад буюу нийгмийн хүчин зүйл гэдэгт донтогч этгээдээс өөрөөс нь хамаарахгүй, түүнийг ийм сэтгэцийн эмгэг байдалд оруулж, хүргэж буй нийгмийн буюу гадаад орчны хүчин зүйлүүд багтана. Ийм хүчин зүйлд дэгдэмхий бодис буюу цавуу, ахуйн хэрэглээний газын хүртээмжтэй байдал, тэдгээрийн хяналтгүй хэрэглээ, нийгмийн тогтворгүй байдал, ядуурал, ажилгүйдэл, нийгмийн ёс суртахууны доройтол, нийгмийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, эцэг, эх, сургууль, багш, хамт олны хараа хяналт,

<sup>15</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004. 295 дахь тал

<sup>16</sup> Б.Болдбаатар, Ж.Мөнхболд. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа. УБ., 2012. 48 дахь тал

<sup>17</sup> Хууль дээдлэх ёс. ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн тайлан. УБ., 2013. 63 дахь тал

хүүхдийн төлөө гэсэн сэтгэл дутах, найз нөхөд, насанд хүрсэн хүмүүсийн сөрөг нөлөө зэрэг нийгмээс хамааралтай, микро түвшний нөхцөл шалтгаанууд хамаарна. Ялангуяа гэр бүлийн болон үе тэнгийнхний нөлөөлөл нь хамгийн нөлөө бүхий хүчин зүйл байгаа судалгаанаас ажиглагдаж байна.

Дотоод буюу хувь хүнтэй холбоотой хүчин зүйл нь хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, гэр бүлийн тогтворгүй байдал, гэр бүл салалт, аав ээж, гэр бүлийн бусад гишүүдтэйгээ үл ойлголцох, зөрчилдөх зэргээс шалтгаалан гэр орноосоо дайжих, хичээл хоцрох, таслах, сурах идэвх сонирхолгүй болох, сурлагадаа амжилт гаргаж чадахгүй байх, ганцаардах, нийгмээс гадуурхагдах, дээрх байдлаас авсан, үүссэн сэтгэлийн шарх, гомдол, хувь хүний сэтгэлийн хат тэнхээ дутах, бухимдал, гутрал зэрэг объектив ба субъектив шалтгаантай байдаг.<sup>18</sup>

Дээрх хүчин зүйлүүдээс шалтгаалан өсвөр үеийнхэн сэтгэл зүйн хямралд орох, гутрах, цөхрөх, ганцаардах, ямар нэгэн арга хэлбэрээр энэ байдлаас гарах, амьдралын баяр баясгаланг эрэлхийлэх зорилгоор бусдын нөлөөнд автах, уруу татагдах, өөрийн гэнэн томоогүй, сониуч зангаасаа болж дэгдэмхий бодис үнэртэн донтож бие махбодь, сэтгэцийн хувьд хохирч байгаа нь туйлаас харамсалтай.

Газ үнэртэж донтож байгаа хүүхдүүдийн дийлэнх хувь нь амьдралын боломж тааруу, эцэг эхийн анхаарал халамж сул, гадуур тэнэдэг, сэтгэл санааны хувьд тогтворгүй, хүмүүжлийн доголдолтой зэрэг нийтлэг байдал ажиглагдаж байна. Мөн амьдралын нөхцөл боломж сайн, хангалуун амьдралтай хүүхдүүд ч найз нөхдөдөө уруу татагдан донтох боллоо.

Монгол Улс дах дэгдэмхий бодис үнэртэж донтох зан үйлийн эмгэгийн өнөөгийн байдал, тоо баримт

Цавуу үнэрлэж донтох эмгэг Монгол улсад 1980 оны дунд үеэс эхлэн дэлгэрсэн гэж үздэг. 1987 онд Улаанбаатар болон томоохон хот суурин газар бензин,

<sup>18</sup> Мөн тэнд. 64 дэх тал

цавуу, будаг үнэртэх эмгэг донтой 105 хүүхэд байсныг илрүүлж эмнэлэг, нийгмийн арга хэмжээг цаг алдалгүй эрчимтэй авч шуурхай таслан зогсоосон байдаг.<sup>19</sup>

Гэвч 1990 оноос эхлэн шилжилтийн үеийн нийгмийн байдал, эдийн засгийн хямралаас шалтгаалан уг үзэгдэл дахин сэргэж газар авах болсон. 2009 оноос ахуйн хэрэглээний газанд мансуурсан, донтсон хэрэг цагдаагийн байгууллагад олноор бүртгэгдэх болсон ба 2012 онд улсын хэмжээнд 142 хүүхэд газ, цавуу бензин үнэрлэж мансуурсан гэсэн судалгаа бий.<sup>20</sup>

2015 оны байдлаар 400 гаруй хүүхэд үнэртэж донтог гэсэн судалгаа гарчээ. Тэдгээрээс зарим ноцтой баримтыг дурдвал: 2015 оны 12-р сарын 28-нд 18 настай эрэгтэй хүүхэд гэртээ ахуйн хэрэглээний газ үнэртэж мансууран эмнэлэгт хүргэгдсэн, 2015 оны 12-р сарын 29-ний өдөр 16-18 насны 3 хүүхэд гэртээ газ үнэртэж мансуурч байгаад ухаан алдсан байдалтай байсан, гэрээс нь 220 граммын ахуйн хэрэглээний газны сав олдсон<sup>21</sup>, 2015 онд 16 настай У, Г нар Баянзүрх дүүрэгт 20 настай охиныг хөнөөж, цогцсыг нь шатаасан ноцтой хэрэг гарч шүүхээс 16 жилийн ял сонссон, уг хэргийг үйлдсэн хүүхдүүд цавуу үнэрлэж мансуурсан үедээ үйлдсэн болох нь тогтоогдсон, 2016 оны 2-р сарын 15-нд Баянзүрх дүүргийн 22-р хороонд 17 настай 10 жилийн сурагчид ахуйн хэрэглээний хий үнэрлэж мансуурсны улмаас 17 настай эрэгтэй Б-ийн биеийн байдал муудаж эмнэлгийн тусламж авч чадалгүй нас барсан хэрэг гарсан<sup>22</sup> зэрэг болно.

Энэ нь нийгэмд токсикмания буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох эмгэг зан үйлийн талаар ойлголт дутмаг, мэдээ, мэдээлэл муу, энэ аюултай үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, эрх зүйн орчин хангалтгүй байгаатай холбоотой.

<sup>19</sup> Л.Эрдэнэбаяр. Донтох эмгэг судлал. УБ., 2004..300 дахь тал

<sup>20</sup> <http://news.gogo.mn/>

<sup>21</sup> Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээ.

<sup>22</sup> [www.medee.mn](http://www.medee.mn)

Токсикмани буюу дэгдэмхий бодис үнэртэж донтохтой тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин

Монгол улсад дэгдэмхий бодис үнэрлэж донтохтой тэмцэх эрх зүйн орчин байхгүй гэж үндсэндээ хэлж болно.

Токсикмани буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох ойлголтыг хууль зүйн үүднээс хуульчилж өгөөгүй, энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй, захиргааны хариуцлага хүлээлгэдэггүй. Дэгдэмхий бодис үнэртэж донтох нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэж мансуурахын адил сэтгэцийн эмгэг, донтох өвчин учраас Эрүүгийн эрх зүйн хүнлэг, энэрэнгүй зарчмын үүднээс ийм бодис хэрэглэсэн, донтсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт олон улсын хэмжээнд ч, Монгол улсад ч байдаггүй. Энэ нь цавуу, ахуйн хэрэглээний газ нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн төдийгүй, химийн хорт бодисын жагсаалтад ч ордоггүй, ахуйн хэрэглээнд чөлөөтэй хэрэглэгддэгтэй холбоотой.

Гагцхүү ахуйн хэрэглээний газыг худалдан борлуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, захиргааны хариуцлага хүлээлгэх цорын ганц хэм хэмжээ байдаг. Хачирхалтай нь ийм зохицуулалт хуульд бус, худалдаа, үйлчилгээний газрууд ахуйн хэрэглээний газ буюу бутаны хийг хяналт, хязгаарлалтгүйгээр насанд хүрээгүй хүмүүст зарж борлуулснаар газыг үнэртэн мансуурч донтох, үүний улмаас амь нас нь хохирсон явдал ихээр гарах болсонтой холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 198-р тогтоолоор батлагдсан "Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам"-д байгаа юм. Уг журамд ахуйн хэрэглээний газыг насанд хүрээгүй хүнд худалдаж борлуулсны улмаас донтож мансуурч, амь нас, эрүүл мэндээрээ хохирсон бол газ худалдсан худалдаа үйлчилгээний газрын тусгай зөвшөөрлийг цуцлах захиргааны арга хэмжээ авахаар заасан байдаг хэдий ч

практик дээр төдийлөн сайн хэрэгжиж чадахгүй байгаа гарч буй хэрэг, зөрчлийн байдлаас харагдаж байна.

Нийслэлээс гаргасан энэхүү журам, сайн туршлагыг дэмжин 2013 онд Дорноговь, Дорнод аймгийн засаг дарга нар “Насанд хүрээгүй хүүхдэд ахуйн хэрэглээний хийн газ худалдаалахыг хориглох тухай” захирамж гаргаж өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай.<sup>23</sup>

### ДҮГНЭЛТ

Токсикмания буюу дэгдэмхий бодис үнэртэж донтох нь насанд хүрээгүй хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг, тэдний амь нас, эрүүл мэндийг эрсдэлтэй байдалд оруулдаг, байнга хэрэглэсэн тохиолдолд тухайн бодист дасч дахин хэрэглэх, донтох сэтгэцийн эмгэг үүсгэдэг, нийгэмд аюултай зан үйл мөн.

Газыг зөвхөн ахуйн хэрэгцээнд хэрэглэдэг гэх ойлголт хэдийнээ хуучирч бидний ирээдүй хойч болсон өсвөр үеийнхэн газыг үнэртэж донтсоор удаж байна, түүний хар сүүдэр нийгмийг бүрхээд байна.

Мансууруулах бодисоос дутуугүй хор аюул дагуулж өсвөр үеийнхнийг маань хордуулан амь нас, эрүүл мэндийг эрсдэлтэй байдалд оруулж байгаа ахуйн хэрэглээний цавуу, газыг үнэртэж донтох асуудалд төрөөс зохих анхаарал хандуулах цаг нэгэнт болжээ. Эс бөгөөс энэ үзэгдэл нийгмийг бүхэлд нь хамарч хэзээ ч нөхөж баршгүй эмгэнэлтэй байдалд хүргэж болзошгүй.

Өсвөр үеийнхэнд маань нүүрлээд байгаа нийгмийн хар тахлын нэг болсон энэ аюултай үзэгдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, холбогдох хууль тогтоомжид зохих өөрчлөлт оруулах нь нэгэнт нийгмийн захиалга, зүй ёсны шаардлага болоод байна.

2016 оны 9-р сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчлэх Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн Тусгай ангийн

16-р бүлгийн 16.2-р зүйлд хүүхдийг донтох байдалд татан оруулах үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь туйлын цаг үеэ олсон эрх зүйн зохицуулалт болсон гэж дүгнэж байна.

### САНАЛ

1. Зөрчлийн тухай хуульд Эцэг эх нь хүүхдэдээ зохих хараа хяналт тавиагүйн улмаас хүүхэд нь дэгдэмхий бодис үнэртэж донтсон, донтсоны улмаас улмаас амь нас эрүүл мэнд хохирсон бол захиргааны хариуцлага хүлээлгэх заалтыг шинээр нэмэх замаар хүүхдийн эрхийг хамгаалах, эцэг эхийн хүүхдэдээ тавих анхаарах халамжийг нэмэгдүүлэх, энэ төрлийн үйлдлээс урьдчилан сэргийлэх;

2. Цавуу, ахуйн хэрэглээний газыг 18 насанд хүрээгүй этгээдэд худалдсан, борлуулсан, түүний улмаас хүүхэд мансуурч амь нас, эрүүл мэндээрээ хохирсон үйлдлийг зөвхөн Улаанбаатар хот, зарим аймгуудад дүрмээр зохицуулж байгааг өөрчлөх, энэ үйлдлийг гаргасан аж ахуйн нэгж, албан тушаалтан, хувь хүнд захиргааны хариуцлага зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд хуульчлах;

3. Улсын хэмжээнд төдийгүй аймаг, нийслэлийн хэмжээнд чимээгүй тахал болоод байгаа цавуу, ахуйн хэрэглээний газ үнэрлэж донтохтой тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгай хөтөлбөр боловсруулж нэн даруй хэрэгжүүлэх;

4. Дэгдэмхий бодис үнэрлэж донтдог хүүхдүүдийг эмчлэх эмч, мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, эмчилгээний сүүлийн үеийн үр дүнтэй шинэ арга, технологийг нэвтрүүлэх, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулах;

5. Дэгдэмхий бодис, түүний хор аюул, дэгдэмхий бодис үнэрлэж донтох эмгэг, өвчний талаар ЕБС-ийн сурагчдад сургалт явуулах, мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг өгөх, урьдчилан сэргийлэх талаар сургууль, багш нараас анхаарч хүүхдийн төлөө ТББ болон цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах, эцэг эхчүүд хүүхдэдээ тавих анхаарал халамжийг сайжруулах зэрэг болно.

<sup>23</sup> www.dornod.gov.mn

**Уншиж танилцан, нийтлэхийг зөвшөөрсөн: Сэтгүүлийн эрхлэгч, хууль зүйн доктор, профессор, дэд комиссар Б.Бат-Эрдэнэ**



МОНГОЛЫН ХУУЛЬ  
САХИУЛАХУЙ